



ӨЛЗИЙТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Ж.РЭНЧИНСАМБУУ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг.
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016 - 11 - 24 № 01/182

Г Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 4,587,290.00 /дөрвөн сая таван зуун наян долоон мянга хоёр зуун ер/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Аудитын хамрах хугацаанд нийт 4,587,290.00 төгрөгийн хүнсний материалыг орцын жишиг нормоор тооцоогүй, хяналтгүй зарцуулж зардалд тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2008 оны 267 тоот тушаалаар баталсан ... Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Яаралтай эмийн нөөцийн үлдэгдлийн тооцоо бодоогүй, санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнаагүй шууд зардалд бичсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, барaa материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойши 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ дахь заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтөлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1101000712

- Холбогдох журам, жишиг орцын нормын дагуу хүнсний материалын зарцуулалтанд хяналт тавих, сар бүр тооцоо бодож баримтжуулж хэвших, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.
- Яаралтай эмийн нөөцийн үлдэгдлийг жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулах, цаашид тооцоо бодож тайланд үнэн зөв тусгаж хэвших
- Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Ж.Рэнчинсамбуу, нягтлан бодогч Б.Буянжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР



Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ

Ж.РЭНЧИНСАМБУУ

НЯГТЛАН БОДОГЧ



Б.БУЯНЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлагын биеэлт хангaedaагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биеэлүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрээгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.